

# БИ ЕСҮС ХРИСТИЙГ ДАГАЖ ЧАДНА



Есүс бусдад үйлчилсэн (Иохан 13:5, 13-17-г үзнэ үү). Би хүмүүст хэрэгтэй зүйлийг олж харж, тэдэнд туслахын тулд хамгийн сайнаараа хичээх болно.



Есүс бусдыг оролцуулсан (Марк 10:14-ийг үзнэ үү). Би бусдыг оролцуулж, орхигдсон тэдэнтэй нөхөрлөж чадна.



Есүс бусдын төлөө залбирсан (3 Нифай 17:15-18-ыг үзнэ үү). Би залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэй ярьж чадна. Би Түүнээс бусдыг адислахыг гуйж чадна.



Есүс бусдыг уучилсан (Иохан 8:11-ийг үзнэ үү). Би бас бусдыг уучилж чадна. Мөн би буруу сонголт хийсэн үедээ, “Намайг уучлаарай” гэж хэлж чадна.



Есүс сайн мэдээг заасан (Матай 5:1-9-ийг үзнэ үү). Би сайн мэдээг бусадтай хуваалцаж чадна. Би хүмүүст Есүсийн тухай зааж чадна.



Есүс төгс үлгэр жишээ байсан (Иохан 13:15-ыг үзнэ үү). Би Есүсийг дагахын тулд хамгийн сайнаараа хичээж чадна. Би бусдад үлгэр жишээ болж чадна.